ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр Дугаар 15/09 Арвайхээр сум

Зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 2.9-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Шанхын баруун хүрээ” хийдийн Хархорин сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Монгол Улсын холбогдох хууль, журам болон өөрийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх, жил бүрийн тогтоосон хугацаанд үйл ажиллагааны тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан ёсоор ирүүлж байхыг “Шанхын Баруун хүрээ” хийдийн тэргүүн Н.Баасандоржид үүрэг болгосугай.

3.Тус хийдийн үйл ажиллагаанд хяналт тавин, холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Хяналтын ажлын хэсгийн ахлагч (С.Ундрах)-д даалгасугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ

ИТХ/nuuts2026/1.togtool/togtool.doc